

Политехникийн дээд сургуулийн хөгжилд профессор Д.Батсуурийн гүйцэтгэсэн үүрэг

академич Ч.Авдай

С.Дашдаваа

ШУТИС

Манай орон 1950-иад оноос эхлэн ЗХУ болон гадаадын зарим оронтой дипломат, мөн эдийн засаг, соёлын харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх бодлого явуулснаар гадаад дотоод таатай нөхцөл бий болж дээрх орнуудын техник эдийн засаг, санхүү, мэргэжилтний тусламжтайгаар түлш эрчим хүч, геологи уул уурхай, барилга, тээвэр холбоо, хөнгөн, хүнсний үйлдвэрүүд шинээр байгуулагдаж, хуучин байсан үйлдвэрүүдийг өргөтгөх, шинэчлэн тоноглох үйл ажиллагаа эхэлсэн юм.

1956 онд төр, засгаас улсын хэмжээнд хөдөлмөрийн нөөцийн судалгаа явуулахад улс ардын аж ахуй, соёлын салбарт ажиллах мэргэжлийн ажилчид, инженер техникийн дээд боловсролтой мэргэжилтний нөөцийг бий болгох нь төрийн бодлогын түвшинд авч үзэж томоохон арга хэмжээ авбал зохих тулгамдсан асуудал болжээ гэж дүгнэлт хийсэн байна. Энэ үед инженер техникийн дээд боловсролтой мэргэжилтнийг ЗХУ-д цөөн тоотой эхлэн бэлтгэж байсны зэрэгцээгээр мэргэжлийн ажилтан, ажилтныг дотооддоо түр курс, фабрик заводын сургууль, сургууль комбинат, техникумаар бэлтгэж байлаа. 1958 онд СНЗ-ийн тогтоолоор үйлдвэр, барилга, тээвэр холбооны техникумуудыг нэгтгэн Политехникумыг байгуулж аж үйлдвэр, барилгын техник, сантехник, цахилгаан, уул уурхайн машины ашиглалт, автоашиглалт, механик, радио холбоо зэрэг ангиудтайгаар зохион байгуулсан нь техникийн дээд боловсролтой мэргэжилтэнг эх орондоо бэлтгэх урьдчилсан нөхцлийг бүрдүүлэхэд чухал алхам болжээ.

Эх орны улс ардын аж ахуйн салбарт ажиллах инженер техникийн дээд боловсролтой мэргэжилтэн нэн шаардлагатай болсныг харгалзан дээд байгууллагын шийдвэрээр МУИС-ийн ректорат 1959 онд физик-математикийн 3-р курсээс 21 оюутныг иргэний ба үйлдвэрийн барилгын инженер, 1960 онд газарзүйн 3-р курсээс 13 оюутныг геологич инженерийн мэргэжлээр сургаж бэлтгэх ажил эхэлсэн бөгөөд 1960 онд эрчим хүч, 1961 онд хөнгөн үйлдвэрийн механикч инженер, 1962 онд автотээврийн инженер, 1963 онд

гидроинженер, инженер – эдийн засаг гэх мэтчилэн хичээлийн жил бүр тус сургуулийн инженерийн салбарт шинэ мэргэжлүүдийн ангиуд нээгдэж байв. Улмаар Политехникийн дээд сургууль байгуулах “Мон-1” төслийг боловсруулан 1966 онд НҮБ-ын соёл боловсрол, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО)-д хандснаар 2 сая ам.долларын өртөг бүхий төсөл хэрэгжиж 1969 онд МУИС-ийн бүрэлдэхүүнд Политехникийн дээд сургуулийг 5 факультет, мэргэжлийн хичээлийн 13 тэнхимтэйгээр байгуулсан байна. Ингэж байгуулахдаа физик математик, хими, нийгмийн ухаан, орос хэл, эдийн засгийн тэнхимүүдийг МУИС, ПДС-ийн хэмжээнд адилхан үйлчилж байхаар МУИС-ийн ректоратаас шийдвэрлэсэн нь инженер техникийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх ажиллагаанд МУИС-д олон жил багшилж, багшлах болон эрдэм шинжилгээний ажлын дадлага туршлагатай болсон багш нараар ерөнхий эрдмийн хичээлүүдийг заалгаж байсан нь ирээдүйн инженерүүдэд суурь мэдлэг гүнзгий олгох ихээхэн боломжийг бүрдүүлсэн гэж үздэг. Тэр үед МУИС-ийн ректороор академич Н.Содном, Ж.Батмөнх, проректороор проф. Г.Миеэгомбо, проф. Д.Батсуурь, Д.Санзайзав, ПДС-ийн захирлаар 1969-1972 онд Л.Дугаржав, 1973-1976 онд Б.Лувсанцэрэн, 1976 оны 4-р сараас Авдай миний бие энэ ажлыг хүлээн авч 1982 он хүртэл МУИС-ийн проректор бөгөөд ПДС-ийн захирал, 1982-1992 оны 7-р сар хүртэл ПДС, ТИС-ийн ректороор ажилласан билээ. МУИС-ийн бүрэлдэхүүнд ПДС байгуулагдаж байсан тэр үед инженер техникийн мэргэжлийн багш нар хуучин нэрээр ЗХУ-аас уригдан ирж ажиллаж байсан эрдэмтэн багш нарыг дагалдан багшлах ажилд сурч, дадлагажиж байсан болохоос судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх түвшинд хүрээгүй байв. Политехникийн дээд сургуулийг байгуулах төсөл хоёр шатаар хэрэгжих байсан юм. Эхний Мон-1 төслөөр сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн хөтөлбөр боловсруулах, хичээлийн лабораториуд

байгуулах, багш бэлтгэх, Мон-2 төслөөр эрдэм шинжилгээний лаборатори байгуулж эрдэм судлалын ажил явуулах боломжийг бүрдүүлэх байсан боловч сүүлчийн төсөл манай талын буруугаар хэрэгжээгүй юм. Гэвч МУИС-ийн бүрэлдэхүүнд байгуулсан ПДС маш богино хугацаанд асар түргэн хөгжиж сургалт хүмүүжлийн ажлаас гадна 1970-аад оноос эхлэн геологи хайгуул, барилгын материал, усжуулалтын чиглэлээр судалгааны ажил явуулахын зэрэгцээгээр үйлдвэрийн газруудтай үр дүн нь шууд үйлдвэрлэлд нэвтрэх ажлыг аж ахуйн гэрээгээр хийж эхэлсэн билээ. Анх эрчим хүчний факультетын багш Х.Сүхбаатар, Ц.Ёндонсамбуу, П.Зориг, Б.Мандах нар "Улаанбаатар хотын нам хүчдлийн шугамын алдагдлыг тодорхойлох", "Улаанбаатар хотын газрын хөрсний хувийн эсэргүүцлийг тодорхойлох" сэдвээр аж ахуйн гэрээт эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэсэн юм. Энэ үеэс проректор Д.Батсуурь багш ПДС-ийн эрдэм шинжилгээ, гадаад харилцааны асуудлыг 1982 онд МУИС-ийн бүрэлдэхүүнээс тусгаарлаж бие даасан дээд сургууль болж гарах хүртэл шууд удирдан явуулж байлаа.

Тэр үед ПДС-ийн багш нар харьцангуй залуу, техникийн ухаанаар эрдмийн зэрэг цолтой багш нар байхгүй шахам байсан учир 1972 онд багш нараас 8 багшийг сонгож ЗХУ-ын дээд сургуулийн аспирантурт сургахаар явуулж байв. Ингээд 1974-1975 онд техникийн ухааны эхний эрдэмтдийг бэлтгэсэн билээ. Ингэж ПДС-ийн багш нар сургууль байгуулсан эхний жилээс эхлэн МУИС-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, ШУА-ийн сурвалжлагч гишүүн, проректор Д.Батсуурь багшийн удирдлагын дор эрдэм шинжилгээний ажлыг эрчимтэй өрнүүлж Монгол орны цахилгаанжуулалт, геологийн тогтоц, зураглал уул уурхай, барилга архитектур, эдийн засаг, технологи, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, усжуулалт, механикжуулалтын чиглэлээр судалгааны ажил хийх арга барилд суралцаж олон арван хүн эрдмийн зэрэг хамгаалсан юм. Тэр үед хийгдэж байсан гол ажлуудаас дурьдвал, профессор Ж.Лхамсүрэнгийн удирдлагаар геологийн салбарын багш, оюутнууд эх орны ашигт малтмал, минералогийн чиглэлээр судалгаа явуулахдаа оюутны үйлдвэрлэлийн дадлагын хугацааг амжилттай ашиглан минералогийн дээжүүдийг цуглуулж минералогийн музей байгуулж энэхүү музейн бүтээл болгон эрдэм шинжилгээний олон арван товхимол нийтлүүлж, музейн үзмэрийг эх орноо сурталчлах, оюутан залуучуудын

лаборатори, дадлагын хичээлд ашиглаж ирсэн бөгөөд одоо энэхүү музей улсын чанартай музей болон өргөжсөн билээ. 1968-онд ПДС, Эрхүүгийн ПДС-ийн хооронд байгуулсан хамтын ажиллагаа өргөжиж 1974 онд хоёр сургууль геологийн мэргэжлийн багш нарын оролцсон "Хэрлэнгийн экспедици"-ийг байгуулан ажиллуулсан юм. Үүнээс өмнө 1972 онд геологийн салбарын хэдэн залуу багш нар ГУУЯ-тай тохиролцож аж ахуйн гэрээгээр Хэнтий аймгийн Дашбалбарын районд 1:200000 масштабтай геологийн судалгааны ажил хийх гэрээ хийгдэж 1973 оноос уг ажлыг эхлүүлэн амжилттай дуусгасан юм. Хэрлэнгийн экспедицийн судалгааны явцад нүүрс, цагаан тугалга, хайлуур жонш, вольфрам зэрэг ашигт малтмалын хэд хэдэн илэрцийг илрүүлж, өмнөд Хэнтийн геологийн тогтоц, тектоник бүтэц, геоморфологийг иж бүрэн судлаж ашигт малтмалын тархацыг тогтоон судалгааны ажлын үр дүнгээр эрдэм шинжилгээний олон улсын болон улсын чанартай эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулж арав гаруй хүн эрдмийн зэрэг хамгаалж, олон арван тайлан, монограф, 200 шахам эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн юм. Хэрлэнгийн экспедицийн ашгаас сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэхэд багагүй хөрөнгө зарцуулсны дээр уг экспедици нь анхнаасаа сургалт, үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний ажлыг хослон явуулах үлгэр дуурайлал болж, сүүлдээ ОХУ-ын эрдэмтдээс гадна Хятадын эрдэмтэд оролцдог, Олон улсын чанартай экспедици болон өргөжсөн билээ. Энэхүү экспедицийг анх байгуулах, экспедицид ажиллаж байсан ПДС-ийн багш Д.Чулуун, С.Дашдаваа, Ж.Ган-Очир Дугараа, Ч.Сэрээготов, О.Гэрэл, Эрхүүгийн ПДС-ийн багш В.И.Сизых, Ю.А.Чернов, Иванов нарын ажлыг бүх талаар амжилттай болгоход проф Д.Батсуурь багш томоохон үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. ПДС 1976-1980 онд 21 сэдвээр, 1981-1985 онд 18 даалгавар 28 сэдвийн хүрээнд судалгааны ажил явуулж байсны дотор Геологи-минералогийн тэнхмээс удирдан явуулсан "Өмнөт Хэнтий, Жанчивлангийн районы геологийн тогтоц, ашигт малтмалын судалгаа", Барилгын материалын тэнхмийн багш нарын "Галд тэсвэртэй тоосго, барилгын хана, хучилгын материалын судалгаа", барилгын хийцийн тэнхмийн "Улаанбаатар хот орчмын хөлдүү хөрсөнд барилгын суурь байгуулах", механикийн тэнхмүүдийн "Машины найдварт ажиллагаа, ашиглалтыг дээшлүүлэх, хүнд хүчир ажлыг

механикжуулах судалгаа", эрчим хүчний мэргэжлийн багш нарын "Эрчим хүчний ашигт ажиллагааны горим тогтоох, нарны эрчим хүчийг ашиглахтай холбогдсон судалгаа", холбооны мэргэжлийн багш нарын "Утсан холбоо, радио нэвтрүүлэх, телесистемийн ажиллагааг найдваржуулах судалгаа", эдийн засгийн мэргэжлийн багш нарын үйлдвэрийн газрын нийгмийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, тэрчлэн хүнсний төрөл бүрийн бүтээгдэхүүн, бага оврын төхөөрөмж бий болгох, чацаргана хураах боловсруулах ажиллагааг механикжуулах, ерөнхий эрдэм, нийгмийн ухааны багш нарын гүйцэтгэсэн олон ажил сайн үр дүнд хүрч үйлдвэрлэлд нэвтэрсний зэрэгцээгээр олон залуу эрдэмтэн төрөн гарч, тэнхимүүдийн судалгаа шинжилгээ, зохион бүтээлтийн ажлын чиглэл улам тодорхой, шинжлэх ухааны түвшин нь жил бүр дээшлэж ирсэн билээ. 1976-1982 онд 62 үйлдвэрийн газарт 10 гаруй сая төгрөгийн төсөвт аж ахуйн гэрээт ажил гүйцэтгэсний дотор 1982 онд улсын төсөвт 22 сэдэв, аж ахуйн гэрээт 42 сэдэвт 3.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэж багш, оюутны оролцох хэмжээ жил ирэх тусам өсч байлаа. Өөрөөр хэлбэл ПДС-ийн тэнхимүүд МУИС-иас салж байгуулагдсан тэр үед бүх тэнхимүүд судалгааны ажлын тодорхой чиглэлтэй болж чадсан юм.

ПДС байгуулагдсны дараагаас Эрхүүгийн ПДС, Москвагийн Эрчим хүч, Барилга уул уурхай, Уралын ПДС, Германы Фрайбергийн уул уурхайн академи, Новосибирскийн Геодези зураглал, эрчим хүч, холбоо, барилгын дээд сургууль болон Хятадын хэд хэдэн их дээд сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулж, багш оюутан солилцох, хамтран судалгаа явуулах болсон нь тус сургуулийн цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж, улмаар их сургууль болон хөгжих суурь тавигдсан гэж зүй ёсоор үздэг. Өөрөөр хэлбэл ПДС-ийг МУИС-ийн бүрэлдэхүүнд байгуулж "хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзаганд хүргэх" хэмжээнд хүртэл хөгжүүлсний үндсэнд бие даасан сургууль болгосон бөгөөд энэхүү ажилд тэр үед МУИС-ийн удирлага, эрдэмтэн багш нар, түүний дотор академич Н.Содном, Ж.Батмөнх, проф. Д.Батсуурь, проф.Г.Мисэггомбо, Д.Санзайзав, Л.Дугаржав, Б.Лувсанцэрэн нарын болон гадаадын мэргэжилтнүүд, багш ажилтнуудын байгуулсан гавъяа сургуулийн түүхэнд мөнхрөн үлдсэн юм. Сайн хүмүүсийн эхлүүлсэн түүхт үйл ажиллагаа улам өргөжин

тэлж эх орны хөгжилд үзүүлж байгаа үр нөлөө нь улам дээшлэн бадрах болтугай.